



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/146

Есөнбулаг

Хүүхдийн төлөө зөвлөлийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 16.4 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Хүүхдийн эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий аймгийн "Хүүхдийн төлөө зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Хүүхдийн хөгжил, оролцоо, хамгааллыг дэмжих, хүүхдийн эрхийг хангах бодлого боловсруулан ажлын уялдаа холбоогоо сайжруулан, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг Хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүд, сумын Хүүхдийн төлөө зөвлөлийн дарга, Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, сум, байгууллагын дарга нарыг удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/523 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2020 оны
02 дугаар сарын 11 -ны өдрийн 4 дугаар
захирамжийн хавсралт

ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн: (Аймгийн Засаг дарга)
(Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын нарийн бичгийн дарга)
(зөвшилцсөнөөр)
(Аймгийн Засаг даргын Тамгын
газрын дарга)
(Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Санхүү, төрийн сангийн хэлтсийн
дарга)
(Боловсрол, шинжлэх ухааны газрын
дарга)
(Биений тамир, спортын газрын
дарга)
(Эрүүл мэндийн газрын дарга)
(Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
газрын дарга)
(Цагдаагийн газрын дарга)
(Онцгой байдлын газрын дарга)
(Соёл урлагийн газрын дарга)
(Ардын дуу бүжгийн "Алтай" чуулгын
дарга)
(Насан туршийн боловсрол төвийн
дарга)
(Есөнбулаг сумын Засаг дарга)
(Эцэг эхийн төлөөлөл ба хүүхдийн
элч)
(зөвшилцсөнөөр)
(Аймгийн Хүүхдийн зөвлөлийн
тэргүүн)
Нарийн бичгийн дарга: (Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил,
хамгааллын газрын дарга)

__оОо__

